

Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдалтай уялдуулан орон нутгийн хамгаалалтад тулгамдаж буй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замыг торийн болон нутгийн захиргааны байгууллагууд, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын толоолол, эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлж, гарах үр дүн, санал, зовломжийг нэгтгэн зохих шатны байгууллагуудад хүргүүлэх болон эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор **“Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал-Орон нутгийн хамгаалалт”**

сэдэвт Эрдэм шинжилгээний хурал Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Олон Улсын хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Олон улсын болон бус нутгийн аюулгүй байдлын орчны оорчлолт, цэрэг-улс торийн байдалд гарч буй оорчлолтоос шалтгаалан улс орнууд газар нутаг, бүрэн эрхт байдлаа оорийн хүчинд тулгуурлах замаар батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч байна. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь тор, захиргааны байгууллагууд, нийт иргэдийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, толоолт бүхий дайчилгаа бөгөөд орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой бие даасан хөгжлийг дэмжих, учирч болзошгүй уламжлалт болон уламжлалт бус аюулаас урьдчилан сэргийлэх, оорийгоо хамгаалах талаар тор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас авч хэрэгжүүлэх олон талт арга хэмжээг улс орны оршин тогтнохын аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс судалж, судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь зэрэг тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх тус хуралд Монгол Улсын их хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга О.Содбилэг, Улсын их хурлын гишүүн Ж.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, Зам тээврийн дэд сайд Б.Цогтгэрэл, БХЯ-ны Торийн нарийн бичгийн дарга бригадын генерал Х.Батбилэг, Стратегийн бодлого толоолтийн газрын дарга бригадын генерал Г.Сайханбилэг, ЗХЖШ-ын I орлогч дарга хошууч генерал Р.Сүхбат нар болон УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, бусад хороод, ҮАБЗ-ийн Ажлын алба, Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, яамд, Хил хамгаалах еронхий газар, Онцгой байдлын еронхий газар, Цагдаагийн еронхий газар, ҮАБЗ-ийн харъяа Стратегийн судалгааны хүрээлэн, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Гамшиг судлалын хүрээлэн, Гео бодлого судлалын хүрээлэн, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, ХУИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургууль, Хууль сахиулахын их сургууль, Үндэсний тагнуулын академи, Улаанбаатар бодлогын судалгааны тов, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, цэргийн штабын дарга нар, Эдийн засгийн бодлого, орсолдох чадварын судалгааны тов зэрэг Торийн болон Торийн цэргийн байгууллагуудын толоолол оролцлоо.

Эрдэм шинжилгээний хурлын үндсэн илтгэлүүд үдээс олно хэлэлцэгдэж, “Бус нутгийн аюулгүй байдлын орчинд гарч буй оорчлолт, хандлага” сэдэвт илтгэлийг доктор /Sc.D/,

профессор О.Үржин, “Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал ба батлан хамгаалах бодлого” илтгэлийг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, тололтийн газрын дарга бригадын генерал Г.Сайханбаяр, “Орон нутгийн хамгаалалтын талаарх зарим улсын туршлага, сургамж” ҮБХИС-ийн эрдэм шинжилгээ, нийгмийн тvншлэл хариуцсан дэд захирал, шинжлэх ухааны доктор /Sc.n/, хурандаа Л.Батцэнгэл, “Орон нутгийн хамгаалалт нь батлан хамгаалах тогтолцооны тулгуур vндэс болох нь” илтгэлийг БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын товийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор Ц.Дашзэвэг, “Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах зарим асуудал” илтгэлийг Батлан хамгаалах аж vйлдвэрийн нэгдлийн дарга, доктор /Ph.D/, профессор С.Баасанхvв нар тус тус тавилаа.

Үдээс хойшхи хурлын ажиллагаа Олон Улсын хурлын танхим, ТОВДС-ийн хурлын танхимд тус тус vргэлжилж, “Орон нутгийн хамгаалалтын эрх зvйн зохицуулалтын зарим асуудал” сэдвийн хvрээнд “Орон нутгийн хамгаалалтын талаарх нэр, томъёо”, “Орон нутгийн хамгаалалтын удирдлага, тололто, зохион байгуулалт”, “Орон нутгийн хамгаалалтад Торийн цэргийн болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг vврэгтэй байгууллагуудын оролцоо”;

“Орон нутгийн хогжил ба орон нутгийн хамгаалалт” сэдвийн хvрээнд “Орон нутгийн тогтвортой хогжлийг хангахад нутгийн захиргааны байгууллагын оролцоо”, “Орон нутгийн эдийн засгийн хогжил нутгийн оорийгоо хамгаалах чадавхийг бэхжvвлэхэд нолоолох нь”, “Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулахад нутгийн захиргааны байгууллагын vврэг, оролцоо” зэрэг асуудлаар хэлэлцvвлэг зохион байгууллаа.

“Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал-Орон нутгийн хамгаалалт” эрдэм шинжилгээний хурал зорилгоо биелvвлж, хэлэлцvвлгийн vр дvнд гарсан санал, зовломжийг нэгтгэн зохих шатны байгууллагуудад хvргvвлэх болон эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулахаар боллоо